

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Сайншанд сумын 5 дугаар багийн 4 дүгээр 58 айлын орон сууцны дээвэр болон гадна фасадны засварын ажил:

А. Барилгын дээврийн засварын ажлыг дараах Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

Б. Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

В. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах

Г. Үнийн саналд Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "Ү" 81-95-12-г мөрдлөг болгоно.

Д. Авто тээврийн зардлыг ЗТЯ-ны 2013.07.10-ны өдрийн 162 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно.

Е. ЗТБХБС-ын 2012 оны 18 дугаар тушаалаар машин механизмын зардлыг тооцож ирүүлнэ.

Ж. Барилгын дээврийн засварын ажлыг дулааны улиралд хийж гүйцэтгэнэ.

1. Ханын дулаалгын ажил:

- Хөөсөн полистрал хавтанцыг хананд тогтоохдоо зориулалтын наалтаар наах ба хуучин гадаргууг бүрэн цэвэрлэж тоос шороог унагаана.

- Бэлэн болсон хананд зураг төслийн дагуу 100 мм зузаантай, 0.5м x 1.0 метрийн хэмжээтэй XPS хөөсөн полистрол хэрэглэх ба MNS EN: 13163:2011 стандартын шаардлага хангасан $\rho=23-25\text{кг/м}^3$ нягттай байна.

- Барилгын дулаан тусгаарлалтын ажлыг зураг төсөлд тусгаагүй материал болон тохирлын гэрчилгээгүй материалаар гүйцэтгэхийг хориглоно. Барилгын ажилд хэрэглэх полистрол хавтанцыг урьдчилан аймгийн ГХБХБГ-ын БМСШЛабораторид болон ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэнд холбогдох үзүүлэлтүүдийг тодорхойлох сорилт, шинжилгээнд хамруулсан байх шаардлагатай.

- Дулаалгын материалыг (нааж төгтөөх) болон гүйцэтгэх дарааллыг зургийн жагсаалт тайлбар бичигт зааснаар хийж гүйцэтгэх шаардлагатай. Наахгүйгээр хөндий зай үүсгэн ивүүр хийж тогтоохыг хориглоно. Тоостой, гөлгөр гадаргуу дээр нааж болохгүй.

- Гүйцэтгэгч нь наалтын чанар болон зууралдалтын бат бэхийн үзүүлэлтийг захиалагч талд туршиж үзүүлнэ. Хөөсөн полистрол хавтанг бороотой үед болон хүйтний улиралд нааж гүйцэтгэхийг хориглоно. Бетон болон тоосгон ханын гадаргууд байх чийгшлийн зөвшөөрөгдөх хэмжээ нь 4°C байна.

- Дулаалгын хавтан хоорондын завсар зайны зөвшөөрөгдсөн хэмжээ нь 2 мм-ээс ихгүй байна. Хэрэв үүнээс их зай гарсан тохиолдолд ижил төрлийн материалаар чигжиж янзлах буюу шахдаг хөөсөөр битүүлнэ. Дулаалгын хөөсөн полистрол хавтангийн зах ирмэгүүд нь хоорондоо нягт нийлсэн байх ёстой.

- Хавтангийн зузаан ялгаа 3 мм-ээс хэтэрч болохгүй.

2. Гадна фасадны өнгөлгөө, засварын ажил:

Төлөвлөгөө
хэрх.

Худах